



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар ТУЗ2023-03/02

Улаанбаатар  
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 59 дугаар зүйлийн 59.1, 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Таван Богд Трейд” ХХК-иас 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/А-84 тоот дугаартай санал, “Жуулчин Дюти Фрий ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.1, 7.2, 7.3 дах хэсэг, 8-р зүйлийн 8.9.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04-р сарын 14-ний өдрийн Баасан гарагийн 16:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, “Жуулчин” ХХК-ийн байр, 2-р давхарт байрлах хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

- 2.1 Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах;
- 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах;
- 2.3 Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах;
- 2.4 Компанийн 2022 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
- 2.5 Компанийн 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах
- 2.6 “Жуулчин Дюти Фрий” Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх;
- 2.7 Компанийг өөрчлөх төслийг танилцуулж, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчилж батлах;

3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт №1-ээр баталж, 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хавсралт №2-оор баталж 2023 оны 03 дугаар сарын 9-ний өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ /Утас: 95958708, [Baterdene.b@tavanbogd.com/](mailto:Baterdene.b@tavanbogd.com/) -тай холбогдон танилцах боломжтойг болохыг мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дүгээр сарын 24-ний өдөр байхаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 3-ны өдрийн 17:00 цаг хүртэл тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Ц.Отгонбаярыг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Б.Намуундарь, гишүүнээр Д.Бүжинлхам томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг хурлын даргад зөвшөөрсүгэй

12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэх ажлыг ханган ажиллахыг Хурлын дарга Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН